

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МЕНЕЖМЕНТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЖУРАМ

/төсөл/

НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмаар Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/-ноос хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, үйл ажиллагааг зохицуулах, хөрөнгө оруулалтын менежментийн компани /цаашид “ХОМК” гэх/-ийн бүтэц, зохион байгуулалт, эрх үүргийг тодорхойлох, хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ байгуулах, сангийн хөрөнгийг удирдахтай холбоотой харилцааг зохицуулна.

1.2. Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагааг Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд заасны дагуу зөвхөн Хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлнэ.

1.3. ХОМК Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 44.7.2-т заасан үнэт цаасыг итгэмжлэн удирдах үйл ажиллагааг хавсран эрхлэхтэй холбоотой харилцааг Хорооноос баталсан “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-аар зохицуулна.

1.4. Энэ журмаар Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 20 дугаар зүйлд заасан хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хөрөнгө итгэмжлэн удирдагчийн үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулахгүй.

ХОЁР. Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд тавих шаардлага

2.1. Хороо хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль болон энэ журамд заасан шаардлагыг хангасан хуулийн этгээдэд олгоно.

2.2. Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн этгээд нь дараах шаардлагыг хангасан байна:

2.2.1. хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагааг эрхлэх хүсэлт гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ нь 200 сая төгрөгөөс доошгүй байх;

2.2.2. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 44.7-д заасан хавсран эрхэлж болох үйл ажиллагаанаас бусад төрлийн үйл ажиллагааг эрхэлдэггүй байх;

2.2.3. энэ журамд заасан бүтэц, зохион байгуулалт, хүний нөөц болон бусад шаардлага;

2.2.4. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 44.5-д тус тус заасан хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан болон үнэт цаасны хөрөнгө оруулалтын зөвлөхүүд нь Хорооноос баталсан тохиромжтой этгээдийг тодорхойлох журамд заасан шаардлагыг хангасан байх;

2.2.5. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 44.3-т заасан хөрөнгө оруулалтын удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байнгын, үнэт цаасны хөрөнгө оруулалтын хоёроос доошгүй зөвлөхтэй байх.

2.2.6. сангийн хөрөнгөөр арилжаа хийх, брокерт захиалга өгөх, брокерийн баталгаажуулалтыг хүлээн авах, арилжааны төлбөрийг гүйцэтгэх, арилжааны гүйлгээтэй холбоотой мэдээллийг хадгалах, хөрөнгө оруулагчид мэдээлэл өгөх бэк оффисын /back office/ програм хангамжтай байх.

2.3. Энэ журмын 2.2.1-д заасан хувь нийлүүлсэн хөрөнгө нь зээлийн эх үүсвэрээс бусад мөнгөн хөрөнгөөс бүрдсэн байна.

ГУРАВ. Бүтэц, зохион байгуулалт, хүний нөөцийн шаардлага

3.1. ХОМК нь гурав буюу түүнээс дээш гишүүнтэй төлөөлөн удирдах зөвлөлтэй байх ба тэдгээрийн олонх нь хараат бус гишүүн байна.

3.2. ХОМК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүнд дараах шаардлага тавина:

3.2.1. санхүүгийн зах зээл дээр 3-аас доошгүй жил ажилласан туршлагатай, энэ чиглэлээр мэргэшсэн байх;

3.2.2. үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхэлж байсан компанийн удирдлагад нь ажиллаж байсан бөгөөд уг компанийн тусгай зөвшөөрөл хүчингүй болсноос хойш 3 жил өнгөрсөн байх;

3.2.3. санхүү, үнэт цаасны зах зээлд гаргасан зөрчлийн улмаас захиргааны хариуцлага хүлээснээс хойш 1 жил өнгөрсөн байх;

3.2.4. хугацаа хэтэрсэн болон шүүхийн шийдвэртэй өр төлбөргүй байх;

3.2.5. эдийн засаг, санхүүгийн эсрэг гэмт хэрэг үйлдэж, ял шийтгэлээр шийтгүүлж байгаагүй байх;

3.2.6. төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн нь Компанийн тухай хуульд зааснаас гадна дараах шаардлагыг хангасан байна:

3.2.6.1. ХОМК болон түүний холбогдох этгээдэд ажил албан тушаал эрхэлдэггүй, эсхүл сүүлийн 3 жилийн хугацаанд эрхэлж байгаагүй;

3.2.6.2. бизнесийн харилцаатай компанийн толгой, эсхүл охин, хараат компанийн ажилтан, албан тушаалтан биш байх;

3.2.6.3. компанийн дүрмээр тогтоосон бусад шаардлага.

3.3. ХОМК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүнээс бусад гүйцэтгэх удирдлага, үнэт цаасны хөрөнгө оруулалтын зөвлөхүүд нь дараах шаардлагыг хангасан байна:

3.3.1. хуульд өөрөөр заагаагүй бол үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээд болон банк, даатгал, бусад санхүүгийн компанийн гүйцэтгэх удирдлага, бусад эрх бүхий албан тушаал хавсран эрхэлдэггүй байх;

3.3.2. гадаадын эсхүл өөрийн орны санхүүгийн зах зээлд санхүү, хөрөнгө оруулалтын чиглэлээр 3-аас доошгүй жилийн туршлагатай мэргэшсэн байх;

3.3.3. тухайн компанитай гэрээгээр ажилладаг кастодиан, үнэлгээний болон аудитийн компанийн эрх бүхий албан тушаалтан, үнэлгээчин, аудиторын холбогдох этгээд биш байх.

3.3.4. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 69.2-т заасан мэргэжлийн холбооноос үнэт цаасны зах зээл дээр хөрөнгө оруулалтын чиглэлээр ажиллах эрх авсан байх.

3.4. Энэ журмын 3.1-д заасан төлөөлөн удирдах зөвлөл дараах журмыг баталсан байна:

3.4.1. төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам;

3.4.2. дотоод хяналтын журам;

3.4.3. ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах журам;

3.4.4. үйл ажиллагааны эрсдэлийн журам;

3.4.5. ёс зүйн дүрэм;

3.4.6. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасан шаардлагыг хангасан мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг бууруулах, удирдах талаар хэрэгжүүлэх төлөвлөгөө, эсхүл дотоод журам;

3.4.7. бусад шаардлагатай журам.

3.5. ХОМК нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, дотоод хяналт, комплайнс болон эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий хариуцсан нэгжтэй, эсхүл хариуцсан ажилтантай байх ба хэрэгжилтэд хяналт тавих этгээд нь төлөөлөн удирдах зөвлөл байна.

3.6. ХОМК нь банк, даатгал, үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх этгээд зэрэг санхүүгийн үйл ажиллагаа эрхэлдэг нэгдлийн оролцогч компани бол тэдгээрийн хооронд үнэ цэнэд нөлөөлж болох материаллаг, олон нийтэд нээлттэй бус мэдээлэл алдагдах, сонирхлын зөрчил үүсэхээс сэргийлэх зорилгоор үйл ажиллагааг заагласан тогтолцоог бүрдүүлсэн байна.

ДӨРӨВ. Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх хүсэлт гаргах, хүсэлтийг хянах, тусгай зөвшөөрөл олгох

4.1. Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйл, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 27, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 45 дугаар зүйлд тус тус заасны дагуу дараах баримт бичгийг хавсарган ирүүлнэ:

4.1.1. тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл /энэ журмын 1 дүгээр хавсралтын дагуу/;

4.1.2. хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар;

4.1.3. компанийн эрх барих дээд байгууллагаас гаргасан хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх талаарх шийдвэр;

4.1.4. компанийн дүрмийн хуулбар;

4.1.5. Хорооноос тогтоосон хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг хангасныг болон үүсгэн байгуулагчдаас оруулсан хөрөнгө нь хууль ёсны орлого болохыг нотлох баримт, үүсгэн байгуулагч нь хуулийн этгээд бол сүүлийн 3 жилийн аудитын байгууллагаар баталгаажуулсан санхүүгийн тайлан, татвар төлөгчийг тодорхойлох баримт;

4.1.6. компанийн нийт хувьцааны 10 болон түүнээс дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;

4.1.7. компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, гүйцэтгэх удирдлага, үнэт цаасны хөрөнгө оруулалтын зөвлөх нь дараах мэдээллийг ирүүлнэ:

4.1.7.1. дэлгэрэнгүй анкет /энэ журмын 2 дугаар хавсралтын дагуу/;

4.1.7.2 үнэт цаасны зах зээлд хөрөнгө оруулалтын чиглэлээр ажил үйлчилгээ эрхлэх эрхийн үнэмлэхний хуулбар;

4.1.7.3 гэмт хэрэгт холбогдож, шийтгэгдэж байгаагүй талаарх цагдаагийн байгууллагын тодорхойлолт;

4.1.7.4 татварын өргүй талаарх татварын байгууллагын тодорхойлолт;

4.1.7.5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны тодорхойлолт;

4.1.7.6. ажлын туршлагаа нотлоход зорилгоор нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар /нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан/;

4.1.7.7. санхүүгийн байгууллагад ажиллаж байхдаа сүүлийн 3 жилийн хугацаанд захиргааны хариуцлага хүлээж байгаагүй, мөн зөрчлийн улмаас тусгай зөвшөөрөл нь цуцлагдсан санхүүгийн байгууллагад эрх бүхий албан тушаал хашиж байгаагүй талаарх мэдээлэл;

4.1.7.8. Хорооноос баталсан тохиромжтой этгээдийг тодорхойлох журамд заасан шаардлагыг хангасан талаарх нотлох баримт.

4.1.8. ажлын байр, тоног төхөөрөмжийн талаарх мэдээлэл, өөрийн байр бол үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ, түрээсийн байр бол түрээсийн гэрээ, тоног төхөөрөмж болон програмын тодорхойлолт;

4.1.9. тухайн компанийн 3 жилийн бизнес төлөвлөгөө, уг төлөвлөгөөг болосруулсан судалгааны тайлан;

4.1.10. зохицуулалтын үйлчилгээний хөлс болон улсын тэмдэгтийн хураамж төлсөн тухай төлбөрийн баримт.

4.2. Хороо хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хүсэлтийг Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль болон энэ журмын дагуу 30 хоногийн дотор хянаж, шийдвэрлэнэ.

4.3. Энэ журмын 4.2-т заасан хугацааг тусгай зөвшөөрөл хүсэж ирүүлсэн баримт бичгийг үнэн зөв, бүрэн гүйцэд, холбогдох хууль тогтоомж, журамд заасан шаардлагыг хангаж ирүүлсэн өдрөөс эхлэн тооцно.

4.4. Хороо хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хугацаагүйгээр олгох бөгөөд дараах шаардлагыг хангасан тохиолдолд олгоно:

4.4.1. эрх бүхий албан тушаалтан нь Хорооноос баталсан тохиромжтой этгээдийг тодорхойлох журамд заасан шаардлагыг хангасан;

4.4.2. хүний нөөцийн хувьд Хорооноос тогтоосон шаардлага хангасан;

4.4.3. ажлын байр, техник болон програм хангамж нь тухайн үйл ажиллагаа эрхлэх шаардлагыг хангасан;

4.4.4. энэ журмаар тогтоосон хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээний шалгуур үзүүлэлтийг хангасан;

4.4.5. хувь нийлүүлсэн хөрөнгөд оногдох мөнгөн хөрөнгийг компанийн холбогдох банкны харилцах дансанд байршуулсан;

4.4.6. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль болон энэ журмаар тогтоосон нөхцөл, шаардлагыг хангасан.

4.5. Энэ журмын 4.4-т заасан шаардлагыг хангаагүй үзвэл Хороо тусгай зөвшөөрөл олгохоос татгалзаж, хүсэлт гаргагчид албан бичгээр мэдэгдэнэ.

4.6. ХОМК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгө, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах хүсэлтийг энэ журмын гуравдугаар хавсралтын дагуу гаргаж, дараах баримт бичгийн хамт Хороонд хавсарган ирүүлнэ:

4.6.1. өөрчлөлт оруулах болсон эрх зүйн үндэслэлийг нотлох баримт;

4.6.2. ХОМК-ийн хувьцааг худалдан авч буй хувьцаа эзэмшигчийн хөрөнгийн гарал үүсэл, тохиромжтой этгээд болох талаарх нотлох баримт;

4.6.3. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасан бусад мэдээлэл, тодорхойлолт;

4.6.4. хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулахтай холбогдуулан зохицуулалттай этгээдийн дүрэмд орох нэмэлт, өөрчлөлтийн төсөл.

4.7. Энэ журмын 4.6-д заасан хүсэлт, холбогдох баримт бичийг Хорооны Ажлын алба Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу ажлын 20 өдрийн дотор хянаж, шийдвэрлэх бөгөөд уг хугацааг бүрдэл бүрэн хангагдсан баримт бичиг ирүүлсэн өдрөөс эхлэн тооцно.

4.8. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах зөвшөөрөл олгож, тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад зохих тэмдэглэгээг хийж, баталгаажуулсны дараа ХОМК нь бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад холбогдох бүртгэлийг хийлгэж, ажлын 15 өдөрт багтаан улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрмийн хуулбарыг Хороонд ирүүлнэ.

4.9. ХОМК нь оноосон нэр, хаяг байршил болон гүйцэтгэх удирдлагаас бусад хувьцаа эзэмшигч өөрчлөгдсөн тохиолдолд компанийн дүрэм, улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг ажлын 5 өдрийн дотор Хороонд хүргүүлнэ.

4.10. ХОМК нь гүйцэтгэх удирдлагыг өөрчлөх хүсэлтийг энэ журмын гуравдугаар хавсралтын дагуу гаргаж, дараах баримт бичгийн хамт Хороонд хавсарган ирүүлнэ:

4.10.1. гүйцэтгэх захирлаар томилох этгээдийн товч намтар;

4.10.2. дээд боловсролын дипломын нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

4.10.3. үнэт цаасны зах зээлд ажиллах эрхийн үнэмлэхний хуулбар;

4.10.4. гүйцэтгэх захирлаар томилсон эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хувь, эсхүл нотариатаар баталгаажуулсан хуулбар;

4.10.5. Тохиромжтой этгээд эсэхийг тодорхойлох баримт бичиг.

4.11. Энэ журмын 4.10-т заасан хүсэлт, холбогдох баримт бичийг Хорооны Ажлын алба холбогдох хууль тогтоомжийн дагуу ажлын 5 өдрийн дотор хянаж, шийдвэрлэх бөгөөд уг хугацааг бүрдэл бүрэн хангагдсан баримт бичиг ирүүлсэн өдрөөс эхлэн тооцно.

ТАВ. ХОМК-ийн үйл ажиллагаанд тавих шаардлага

5.1. ХОМК нь үйл ажиллагаандаа дараах шаардлагыг хангаж ажиллана:

5.1.1. Хорооноос баталсан “Компанийн засаглалын кодекс”-ийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллах;

5.1.2. мэргэжлийн ёс зүйтэй байх;

5.1.3. хүлээсэн үүргээ биелүүлэх, сонирхлын зөрчил үүсэхээс сэргийлж ажиллах;

5.1.4. хөрөнгө оруулагчийн эрх ашгийг тэргүүн ээлжинд тавих;

5.1.5. бие даасан, хараат бус байх;

5.1.6. хөрөнгө оруулагчийг үнэн зөв мэдээллээр цаг тухайд нь бүрэн хангах;

5.1.7. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, холбогдох бусад хууль, энэ журамд заасан шаардлагыг мөрдөн ажиллах.

5.2. ХОМК нь Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 14.1-д зааснаар Хорооноос үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авснаар хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулна.

5.3. ХОМК нь хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулснаар тухайн сангийн хөрөнгийг удирдах, хадгалуулах үүргийг хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний үндсэн дээр гүйцэтгэнэ.

5.4. ХОМК нь удирдаж буй хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийг зөвхөн кастодианы үйл ажиллагаа эрхлэх этгээдэд хадгалуулна.

5.5. ХОМК-ийн эрх бүхий албан тушаалтан, үнэт цаасны хөрөнгө оруулалтын зөвлөх нь ёс зүйн дүрмийг үйл ажиллагаандаа тогтмол мөрдөж ажиллана.

5.6. ХОМК нь хамтын хаалттай ХОС-д хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээг үзүүлдэг бол уг сангийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 5 хувиас доошгүй хэмжээгээр хөрөнгө оруулалт хийж, уг хязгаарсан буурсан тохиолдолд нэмэлт хөрөнгө оруулалтыг тухай бүр санд оруулна.

5.7. ХОМК энэ журмын 5.6-д заасан оруулсан хөрөнгөө зөвхөн сангийн үйл ажиллагааны хугацаа дуусгавар болж, бүх өр төлбөрийг барагдуулан бусад нэгж эрх эзэмшигчдийн хөрөнгийг хуваарилсны дараа эргүүлж авна.

ЗУРГАА. Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ

6.1. ХОМК нь хөрөнгийн оруулалтын сангийн активын удирдлагыг хэрэгжүүлэх хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ /цаашид “гэрээ” гэх/-г байгуулсны үндсэн дээр холбогдох үйлчилгээг үзүүлнэ.

6.2. Энэ журмын 6.1-д заасан гэрээнд дараах зүйлийг тусгана:

6.2.1. итгэмжлэн удирдах сангийн актив, үнэт цаасны төрөл, хувь хэмжээ;

6.2.2. талуудын эрх, үүрэг;

6.2.3. сангийн нэгж эрхийг эргүүлэн худалдаж авах зохицуулалт;

6.2.4. үйлчилгээний төлбөр, урамшуулал болон түүнтэй холбоотой бусад мэдээлэл;

6.2.5. хөрөнгө итгэмжлэн удирдах хөрөнгийн удирдлага;

6.2.6. гэрээг цуцлах үндэслэл, журам;

6.2.7. давагдашгүй хүчин зүйл /форс-мажор/-ийн нөхцөлүүд;

6.2.8. хэрэглэх хууль тогтоомжийн хүрээ болон маргаан шийдвэрлэх журам;

6.2.9. хуулиар хориглоогүй бусад шаардлагатай мэдээлэл.

6.3. Энэ журмын 6.1-д заасан гэрээнд өөрөөр заагаагүй бол ХОМК-ийн үйлчилгээний хөлс, урамшууллын хэмжээг нэмэгдүүлэх, хөрөнгө итгэмжлэн удирдах хугацаанд өөрчлөлт оруулах

асуудлыг зөвхөн хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигч гишүүдийн хурлын шийдвэрээр өөрчлөлт оруулна.

6.4. Энэ журмын 6.3-т заасны дагуу гэрээнд орсон өөрчлөлтийг ажлын 3 өдрийн дотор Хороо болон сангийн нэгж эрх эзэмшигчид мэдээлнэ.

ДОЛОО. ХОМК-ийн үүрэг

7.1. ХОМК нь Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 44.8-д зааснаас гадна дараах үүрэгтэй:

7.1.1. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Хорооноос баталсан дүрэм, журам болон гэрээний хүрээнд тухайн сангийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх;

7.1.2. Хорооноос холбогдох хууль тогтоомж, бүрэн эрхийн хүрээнд өгсөн үүрэг даалгаврыг тухай бүр биелүүлж ажиллах;

7.1.3. сангийн гишүүдийн эрх ашгийн төлөө, сонирхлын зөрчилгүй, бие даасан, хараат бус үйл ажиллагаа явуулах;

7.1.4. ХОС-ийн хөрөнгө оруулалтын багц, эрсдэлийн удирдлагыг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн нийтлэг стандарт зөвлөмж, сангийн дотоод дүрэм, журмын хүрээнд хэрэгжүүлэх;

7.1.5. хамтын ХОС-ийн хувьд хөрөнгө оруулалт хийх боломжтой байгаа хөрөнгийн төрлийн талаар төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулах;

7.1.6. хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичиг, стратегийн хүрээнд сангийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийж, хөрөнгө оруулагчдын оруулсан хөрөнгийн өгөөжийг нэмэгдүүлэхэд шаардлагатай бүх хүчин чармайлт гаргаж ажиллах;

7.1.7. кастодианы хадгалалтад шилжүүлэх хөрөнгийг кастодианаас тодорхойлсон хэлбэр, горимын дагуу шилжүүлэх;

7.1.8. хамтын нээлттэй ХОС-ийн хувьд өөрийн цэвэр активын үнэлгээг өдөр тутам тооцож, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэх;

7.1.9. хамтын ХОС-ийн хувьд төлөөлөн удирдах зөвлөлийн зөвшөөрөлгүйгээр сангийн хөрөнгийг хадгалах, хөрөнгө удирдах болон зөвлөх үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой аливаа гэрээ, хэлцлийг тухайн сангийн нэрийн өмнөөс байгуулахгүй байх;

7.1.10. нэгээс дээш тооны ХОС-д үйлчилгээ үзүүлж байгаа тохиолдолд сан тус бүрийн хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичиг, стратеги, дотоод дүрэм, журмын хүрээнд хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх, тэдгээрийн хооронд сонирхлыг зөрчил үүсгэхээс сэргийлж, шударга, ил тод байх зарчмыг мөрдөж ажиллах;

7.1.11. харилцагчийг таньж мэдэх, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс сэргийлэх чиглэлээр сангийн дотоод дүрэм, журам, хөтөлбөрт заасан арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлэх.

НАЙМ. Хариуцлага

8.1. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн болон хүчингүй болгосон тухай Хорооны шийдвэр гарснаас хойш уг үйл ажиллагааг үргэлжлүүлэн эрхэлбэл тусгай зөвшөөрөлгүйгээр үйл ажиллагаа эрхэлсэн гэж үзэж Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай болон холбогдох бусад хуульд заасан хариуцлага хүлээлгэх үндэслэл болно.

8.2. Хороо энэ журмын биелэлтэд хяналт тавьж, зөрчсөн этгээдэд Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай болон холбогдох бусад хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

8.3. Хорооны шийдвэрийг үл зөвшөөрсөн этгээд шийдвэр гарснаас хойш Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 28 дугаар зүйлд заасны дагуу Хорооны дэргэдэх Хяналтын зөвлөлд гомдол гаргаж болно.

~o0o~

Санхүүгийн зохицуулах хорооны ... оны ... тогтоолоор баталсан
 “Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх
 тусгай зөвшөөрлийн журам”-ын 1 дүгээр хавсралт

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МЕНЕЖМЕНТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ХҮССЭН ӨРГӨДӨЛ

Өргөдөл гаргасан огноо	Он		Сар		Өдөр	
Өргөдөл гаргагч хуулийн этгээдийн оноосон нэр	Монгол					
	Англи (Хуулийн этгээдийн нэрийг латин үсгээр галиглан бичнэ)					
Улсын бүртгэлийн дугаар						
Регистрийн дугаар						
Хүсэлт гаргагчийн талаарх мэдээлэл						
Үүсгэн байгуулагдсан огноо	Он		Сар		Өдөр	
Үйл ажиллагааны цэвэр ашиг /төгрөгөөр/						
Хөрөнгө оруулалтын хэлбэр	<input type="checkbox"/> Дотоодын хөрөнгө оруулалттай <input type="checkbox"/> Гадаадын хөрөнгө оруулалттай					
Хаяг байршил	Аймаг/хот					
	Сум/дүүрэг					
	Баг/хороо					
	Гудамж, байр					
	Тоот					
Холбоо барих утас						
Цахим шуудангийн хаяг						
Цахим хуудас						
Удирдлага, мэргэшсэн хүний нөөцтэй холбоотой мэдээлэл:						
Нийт ажилтан, албан хаагчдын тоо						
Албан тушаал	Овог, нэр	Харьяалал	Регистрийн дугаар	Утасны дугаар	Эзэмшсэн мэргэжил	Дипломын дугаар
ТУЗ-ийн дарга						
ТУЗ-ийн гишүүд						
Гүйцэтгэх захирал						
Мэргэшсэн нягтлан бодогч						
Үнэт цаасны хөрөнгө оруулалтын зөвлөх						
Бусад						
Хувь нийлүүлсэн хөрөнгийн талаарх мэдээлэл:						
Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ						
Хувьцаа эзэмшигчдийн овог, нэр/хуулийн этгээдийн нэр	Хувьцааны тоо ширхэг	Хувьцааны төрөл		Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ	Хувь нийлүүлсэн хөрөнгөд эзлэх хувь	

		<input type="checkbox"/> ДЭХ	<input type="checkbox"/> ЭХ		
		<input type="checkbox"/> ДЭХ	<input type="checkbox"/> ЭХ		
		<input type="checkbox"/> ДЭХ	<input type="checkbox"/> ЭХ		
		<input type="checkbox"/> ДЭХ	<input type="checkbox"/> ЭХ		
		<input type="checkbox"/> ДЭХ	<input type="checkbox"/> ЭХ		

Ашиглах техник тоног төхөөрөмж, программ хангамжийн талаарх мэдээлэл

Техник, тоног төхөөрөмжийн нэр төрөл	Техникийн үзүүлэлт	Худалдан авсан	Түрээсэлсэн	Тоо ширхэг	Үнэ /төгрөгөөр/
Программ хангамжийн нэр төрөл	Програмын зориулалт	Худалдан авсан	Түрээсэлсэн	Тоо ширхэг	Үнэ /төгрөгөөр/

Бүртгүүлэхээр мэдүүлж байгаа мэдээлэл, нотлох баримтыг бүрэн гүйцэд, үнэн зөв гаргаж өгсөн бөгөөд хэрэв уг бүрдүүлсэн баримт бичигт аливаа худал ташаа зүйл байвал хариуцлагыг бид хүлээх болно.

Өргөдөл, холбогдох баримт бичгийг хянан шалгаж, хөрөнгө оруулалтын менежментийн компанийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгоно уу.

Бид үйл ажиллагаандаа Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Аж ахуй үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай болон бусад холбогдох хууль тогтоомж, журам заавруудыг мөрдлөг болгон ажиллах ба Санхүүгийн зохицуулах хорооноос тавьсан шаардлагуудыг бүрэн хангаж, биелүүлж ажиллана.

Өргөдөл гаргах эрх бүхий этгээд /тохирохыг сонгож “√” тэмдэглээ хийнэ./:

- Гүйцэтгэх удирдлага
- Үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч
- Итгэмжлэлээр эрх олгогдсон бусад этгээд

Овог, нэр: Регистрийн дугаар:
 Албан тушаал: Утасны дугаар:

Өргөдөл гаргагч:

Хуулийн этгээдийн
Тэмдэг

_____ /_____ /


/гарын үсэг/

/гарын үсгийн тайлал/

**ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН БОЛОН БУСАД МЭРГЭШСЭН ХҮНИЙ НӨӨЦИЙН
ТОДОРХОЙЛОЛТ**

1. Ерөнхий мэдээлэл

Ургийн овог:	
Овог нэр:	
Регистрийн дугаар:	
Иргэний харьяалал:	
Хүсэлт гаргагчид эрхлэх албан тушаал:	
Оршин суугаа газрын хаяг:	
Гар утасны дугаар:	
Цахим шуудангийн хаяг:	



2. Боловсрол /Ерөнхий боловсролын сургуулийг оролцуулан бичнэ/

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн огноо	Төгссөн огноо	Диплом, гэрчилгээний дугаар

3. Ажлын туршлага

№	Хаана ажиллаж байсан	Албан тушаал	Ажилд орсон огноо	Ажлаас гарсан огноо	Шалтгаан

4. ТУЗ-ийн дарга, гишүүн, гүйцэтгэх удирдлага бусад мэргэшсэн хүний нөөцийн холбогдох
этгээдийн байдал

№	Таны хэн болох	Овог, нэр /Хуулийн этгээдийн нэр/	Регистрийн дугаар	Эрхэлж буй ажил, албан тушаал

Миний бие дээр мэдүүлсэн мэдээллийг бүрэн дүүрэн, үнэн зөв болохыг баталж байна.

Тодорхойлолт гаргасан:

/...../ /.....//...../
/овог, нэр/ /гарын үсэг/ /огноо/

**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МЕНЕЖМЕНТИЙН КОМПАНИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН
ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ, ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ, ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГАД ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ ӨРГӨДӨЛ**

Өргөдөл гаргасан огноо	Он		Сар		Өдөр		
Өргөдөл гаргагч хуулийн этгээдийн оноосон нэр							
Улсын бүртгэлийн дугаар							
Регистрийн дугаар							
Дараах төрлөөс сонгоно уу.							
<ul style="list-style-type: none"> ○ Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах ○ Хувьцаа эзэмшигчид өөрчлөлт оруулах ○ Гүйцэтгэх удирдлагад өөрчлөлт оруулах 							
Хэсэг 1. Хувь нийлүүлсэн хөрөнгө /ХНХ/-ийн хэмжээнд өөрчлөлт оруулах							
Овог, нэр/ Хуулийн этгээдийн нэр	Регистрийн дугаар	Одоогийн ХНХ-ийн хэмжээ (₮)	Нэмэгдсэн (₮)	Хорогдсон (₮)	Өөрчлөлт орсны дараах ХНХ-ийн хэмжээ (₮)	ХНХ-д эзлэх хувь	
<i>Тэмдэглэл: (Дээрх мэдээллийг хувьцаа эзэмшигч бүрээр бичнэ.)</i>							
Хэсэг 2. Хувьцаа эзэмшигчид өөрчлөлт оруулах							
Овог, нэр/ Хуулийн этгээдийн нэр	Эцсийн өмчлөгч эсэх	ХНХ-ийн 5, түүнээс дээш хувийг эзэмшдэг эсэх	Харьяалал	Регистрийн дугаар	Хувьцааны тоо (ш)	ХНХ-ийн хэмжээ (₮)	ХНХ-д эзлэх хувь
Хэсэг 3. Гүйцэтгэх удирдлагад өөрчлөлт оруулах							
Албан тушаал	Овог нэр	Харьяалал	Регистрийн дугаар	Мэргэжил	Утасны дугаар		

Өргөдөл гаргасан:

/...../ /...../

/овог, нэр/

/гарын үсэг/

/огноо/